

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/52 / А-82

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, оорчлолт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.2 дахь заалт, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн 7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төлөвлөгөө, журам батлах тухай А/102, А-177 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгож буй хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журам”-ын 3.2.8 дахь заалтын “...хийгдэх” гэсний дараа “...бөгөөд банк тогтоосон хуваариас өмнө санхүүжилтийн үндсэн төлбөрийг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр төлж болно” гэж, 3.3.1 дэх заалтын “...дахь” гэсний дараа “...үлдэгдэл...” гэж, 3.3.5 дахь заалтын “...хийгдэх” гэсний дараа “...бөгөөд банк тогтоосон хуваариас өмнө хуваарьт санхүүжилтийн үндсэн төлбөрийг хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр төлж болно” гэж тус тус нэмсүгэй.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Төлөвлөгөө, журам батлах тухай А/102, А-177 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгож буй хөнгөлөлттэй санхүүжилтийн журам”-ын 3.2.4 дэх заалтын “...6 сар хүртэл хугацаатай...” гэснийг “...2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл төлөгдөх нөхцөлтэй...” гэж, 3.2.5 дахь заалтын “...2020 он...” гэснийг “...2021 он...” гэж, 3.3.3 дахь заалтын “...24 сар хүртэл...” гэснийг “...36 сар хүртэл...” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газар /Б.Элбэгзаяа/, Монголбанкны Ноогийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар /А.Энхжин/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус даалгасугай.

